

**БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР, ЦЕХЭД ТҮҮХИЙ СҮҮ НИЙЛҮҮЛСЭН МАЛЧИН,
ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙ ЭРХЛЭГЧДЭД МӨНГӨН УРАМШУУЛАЛ
ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүүг нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгохтой холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчээс сүү боловсруулах үйлдвэр, цехэд нийлүүлсэн сүүний нэгж/(литр) тутамд олгох мөнгөн урамшууллын хэмжээг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

1.3. Мөнгөн урамшууллыг улсын хэмжээнд тухайн оны 11 дүгээр сараас дараа оны 04 дүгээр сарыг дуустал хугацаанд сүү боловсруулах үйлдвэр, цехэд тушаасан түүхий сүүнд хамаарна.

Хоёр: Малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгоход тавигдах шаардлага

2.1. Малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид дараах нийтлэг шаардлага тавигдана:

- 2.1.1. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан мэдээллийн цахим санд бүртгэгдсэн;
- 2.1.2. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн хүрээнд малаа эрүүл мэнд, үржлийн үйлчилгээнд тогтмол хамруулдаг байх;
- 2.1.3. Малын генетик нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх хэсэгт заасан бүртгэлд хамрагдсан;
- 2.1.4. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль тогтоомжид заасан хөдөө аж ахуйн зохистой дадлын нөхцөл, үйл ажиллагааг хангасан; /аргачилсан зөвлөмж/
- 2.1.5. Малын түүхий сүүний стандарт MNS4228:2011-ын шаардлагад нийцсэн сүү бэлтгэдэг байх;

Гурав. Малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн бэлтгэсэн түүхий сүүг хүлээн авах боловсруулах үйлдвэр, цехэд тавигдах нийтлэг шаардлага

3.1. Сүү боловсруулах үйлдвэр, цехэд дараах шаардлага тавигдана:

- 3.1.1. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан мэдээллийн цахим санд бүртгэгдсэн;
- 3.1.2. Үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн зохистой дадлын нөхцөл, үйл ажиллагааг хангасан;
- 3.1.3. Түүхий сүүг техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн эсэхийг тодорхойлох багаж тоног төхөөрөмж мөн баталгаажсан жин хэмжүүртэй байх;

3.1.4. Үйлдвэр, цехэд түүхий сүү нийлүүлэх, худалдах үез мөрдөх эрүүл ахуй, ариун цэврийн зааврыг хангасан;

Дөрөв. Малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох, тайлагнах, хяналт тавих

4.1. Малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох үйл ажиллагааг “Мал амьтны эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн сан”-аар дамжуулан зохион байгуулна.

4.2. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд заасан мал амьтны эрүүл мэндийг хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх эрүүл тайван байдлыг баталгаажуулахтай холбогдсон арга хэмжээ болон бусад үйл ажиллагааны мэдээллийг тухай бүр, “Мал амьтны эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, тайлагнах” журмын 2.1. дэх хэсэгт заасан батлагдсан маягт, зааврын дагуу үзүүлэлт тус бүрээр бүртгэж, баталгаажуулж мэдээллийн санд бүртгэнэ.

4.3. “Мал амьтны эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн сан” нь тухайн онд урамшуулалд хамрагдсан малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн бүртгэл, мөнгөн урамшууллын хуваарилалт, зарцуулалтын мэдээ, тайланг жил бүрийн 06 дугаар сарын 1-ны дотор багтаан Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам болон Сангийн яаманд тус тус хүргүүлнэ.

4.4. Мөнгөн урамшууллын хуваарилалт, олголтын явцад хяналт хийх ажлыг Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгж зохион байгуулах ба шалгалтын дүнг Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам болон Сангийн яаманд тухай бүр хүргүүлж байна.

Тав. Хариуцлага

5.1. Энэхүү журмын хэрэгжилтэд Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

5.2. Энэхүү журамд нарийвчлан тодорхойлсноос бусад бүртгэл, мэдээллийн сангийн тайлагнахтай холбоотой хариуцлага нь Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль, холбогдох бусад хууль, дүрэм, журмаар зохицуулагдана.